ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ЗАА-2022/119/СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежерийн үүргийг түр
орлон гүйцэтгэгч : Г.Заяа
Утас:92038288
Цахим хаяг:zayag@audit.gov.mn

Интер аудит ХХК
Гэрээт аудитор: Г.Алтанцэцэг
Утас: 99469299, 90111091
Цахим хаяг: altan_fin@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт ....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .... 6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .... 8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .... 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .... 10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .... 12
3. Аудитын тайлан ....13
3.1 Ерөнхий зүйл .... 13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .... 13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .... 14
3.4 Материаллаг байдал .... 14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .... 14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .... 15
3.6.1 Төсвийн төлөвлөлт .... 15
3.6.2 Төсвийн гүйцэтгэл .... 15
3.6.3 Нэмэлт төсөв .... 15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .... 15
3.8 Аудитын гол асуудал .... 15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .... 15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .... 16
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .... 16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .... 16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .... 16
4. Аудитын илрүүлэлт ....16
4.1 Завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудит .... 16
4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит .... 16
4.2.1 Залруулсан алдаа .... 16
4.2.2 Төлбөрийн акт .... 16
4.2.3 Албан шаардлага .... 17
4.2.4 Зөвлөмж .... 17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....18

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |

## 1.Аудитын санал дүгнэлт

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12

2022.02.22 № 1202/123

танай_______________-ны №_______________-т

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН
ТӨВИЙН ДАРГА Ж.МӨНХЦЭЦЭГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

01302?053

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **35,182.61** | **38,018.73** |
| **33** | **АВЛАГА** | 6,220.65 | 7,941.09 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 2,220.32 |
| **335** | **Бусад авлага** | 6,220.65 | 5,720.78 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 6,220.65 | 5,720.78 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 28,961.96 | 30,077.64 |
| **351** | **Түүхий эд материал** | 18,048.46 | 15,985.63 |
| 35130 | Эм боох материал | 18,048.46 | 15,985.63 |
| **354** | **Хангамжийн материал** | 10,913.50 | 14,092.01 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 459.50 | 557.60 |
| 35420 | Аж ахуйн материал | 9,654.00 | 12,184.51 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 800.00 | 293.40 |
| 35450 | Барилгын засварын материал | - | 1,056.50 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **324,602.68** | **315,367.98** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 324,602.68 | 315,367.98 |
| **392** | **Биет хөрөнгө** | 289,332.68 | 280,097.98 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 217,578.51 | 217,578.51 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (8,657.37) | (12,776.05) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 130,618.00 | 150,118.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (75,459.67) | (103,547.17) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 79,059.06 | 89,271.16 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (58,068.75) | (64,261.45) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 9,426.63 | 9,426.63 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (8,665.54) | (9,063.46) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,523.30 | 1,523.30 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (1,085.80) | (1,235.80) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 3,064.30 | 3,064.30 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 35,270.00 | 35,270.00 |
| 39301 | Програм хангамж | 2,319.93 | 2,319.93 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,319.93) | (2,319.93) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 35,270.00 | 35,270.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **359,785.28** | **353,386.71** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **6,220.65** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 6,220.65 | - |
| **413** | **Өглөг** | 6,220.65 | - |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 6,220.65 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **353,564.63** | **353,386.71** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 353,564.63 | 353,386.71 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 283,361.97 | 283,361.97 |

| | | | |
|---|---|---|---|
| 51101 | Өмч: - төрийн | 283,361.97 | 283,361.97 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 44,891.40 | 44,713.47 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 44,891.40 | 44,891.40 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (177.92) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 25,311.27 | 25,311.27 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **359,785.28** | **353,386.71** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **398,068.63** | **528,617.31** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **56,656.93** | **126,978.41** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 56,656.93 | 126,978.41 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 56,656.93 | 81,087.75 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 1,960.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | - | 6,220.65 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 56,656.93 | 72,907.10 |
| 120009 | Бусад орлого | - | 45,890.66 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **341,411.70** | **401,638.90** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 333,411.70 | 355,755.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 333,411.70 | 355,755.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 23,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 23,800.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 8,000.00 | 5,500.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 8,000.00 | 22,083.90 |
| 133005 | Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт | - | 16,583.90 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **358,884.25** | **528,795.23** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **358,884.25** | **528,795.23** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 357,938.05 | 495,467.64 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 252,077.94 | 264,730.87 |
| 210101 | Үндсэн цалин | 252,077.94 | 264,730.87 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 33,371.76 | 36,627.53 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,371.76 | 36,627.53 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,533.79 | 12,533.67 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,848.63 | 1,752.90 |
| 210302 | Түлш, халаалт | 9,154.52 | 9,199.96 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 530.64 | 1,580.81 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,328.12 | 18,857.96 |
| 210401 | Бичиг хэрэг | 846.40 | 1,594.55 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,094.60 | 9,447.46 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,090.08 | 1,511.29 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 210.30 | 180.20 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,086.74 | 2,985.46 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 3,139.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 6,009.75 | 72,318.09 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 6,009.75 | 62,049.09 |
| 210502 | Хоол, хүнс | - | 10,269.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,183.05 | 7,383.90 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,405.85 | 1,573.60 |
| 210604 | Урсгал засвар | 3,777.20 | 5,810.30 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 8,427.70 | 34,238.40 |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,427.70 | 34,238.40 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,847.79 | 9,330.43 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 7,980.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 540.00 | 432.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 347.94 | 161.18 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 404.60 | 186.69 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66.00 | 55.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 419.00 | 198.00 |
| 210807 | Газрын төлбөр | 55.20 | 317.56 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 15.05 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 27,158.15 | 39,446.80 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 27,158.15 | 38,946.80 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 946.20 | 33,327.60 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 181.00 | 23,990.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 181.00 | 23,990.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 6,985.85 | 3,116.95 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,985.85 | 3,116.95 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | (6,220.65) | 6,220.65 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | (6,220.65) | 6,220.65 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **39,184.37** | **(177.92)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **39,184.37** | **(177.92)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | - | - |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **283,361.97** | **25,311.27** | **44,891.40** | 353,564.63 |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **283,361.97** | **25,311.27** | **44,891.40** | 353,564.63 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **283,361.97** | **25,311.27** | **44,891.40** | 353,564.63 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (177.92) | (177.92) |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **283,361.97** | **25,311.27** | **44,713.47** | 353,386.71 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **341,411.70** | **455,710.21** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **54,071.31** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 54,071.31 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | - | 8,180.65 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 1,960.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | - | 6,220.65 |
| 120009 | Бусад орлого | - | 45,890.66 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **341,411.70** | **401,638.90** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 333,411.70 | 355,755.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 333,411.70 | 355,755.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 23,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 23,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 8,000.00 | 5,500.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 8,000.00 | 5,500.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | - | 16,583.90 |
| 133005 | Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт | - | 16,583.90 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **341,411.70** | **449,429.21** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **341,411.70** | **449,429.21** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **334,244.85** | **422,322.26** |

| | | | |
|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 242,248.57 | 269,882.92 |
| 210101 | Үндсэн цалин | 137,993.79 | 165,049.32 |
| 210102 | Нэмэгдэл | 69,862.18 | 74,031.43 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 11,907.20 | 9,862.03 |
| 210104 | Урамшуулал | 22,485.40 | 20,940.14 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 32,988.03 | 43,881.04 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,893.13 | 31,306.34 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,219.00 | 2,514.90 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,994.40 | 4,526.90 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 443.50 | 503.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,438.00 | 5,029.90 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,533.79 | 13,683.66 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,848.63 | 1,752.90 |
| 210302 | Түлш, халаалт | 9,154.52 | 10,349.96 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 530.64 | 1,580.81 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,986.12 | 19,156.77 |
| 210401 | Бичиг хэрэг | 915.40 | 1,681.65 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,094.60 | 9,733.66 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,090.08 | 1,511.29 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 210.30 | 360.20 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,675.74 | 5,869.97 |
| **2105** | **Нормативт зардал** | 13,350.00 | 22,895.26 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 12,283.00 | 9,686.26 |
| 210502 | Хоол, хүнс | - | 10,269.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,067.00 | 2,940.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 13,862.85 | 7,933.80 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,221.35 | 1,600.20 |
| 210604 | Урсгал засвар | 7,641.50 | 6,333.60 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 8,427.70 | 34,558.40 |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,427.70 | 34,558.40 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,847.79 | 9,330.43 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 7,980.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 540.00 | 432.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 347.94 | 161.18 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 404.60 | 186.69 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66.00 | 55.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 419.00 | 198.00 |
| 210807 | Газрын төлбөр | 55.20 | 317.56 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 15.05 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 1,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 1,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **7,166.85** | **27,106.95** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 181.00 | 23,990.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 181.00 | 23,990.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 6,985.85 | 3,116.95 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,985.85 | 3,116.95 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **-** | **6,281.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **6,281.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **6,281.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 6,281.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 6,281.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(6,281.00)** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 355,755.00 | 352,638.05 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 355,755.00 | 352,638.05 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 355,395.00 | 352,448.05 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 251,492.90 | 251,492.90 |
| 210101 | Үндсэн цалин | 150,572.80 | 146,659.30 |
| 210102 | Нэмэгдэл | 65,860.20 | 74,031.43 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12,474.00 | 9,862.03 |
| 210104 | Урамшуулал | 22,585.90 | 20,940.14 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 36,466.50 | 36,466.50 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,891.80 | 23,891.80 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,514.90 | 2,514.90 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,526.90 | 4,526.90 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 503.00 | 503.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,029.90 | 5,029.90 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 14,543.20 | 13,683.66 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,562.40 | 1,752.90 |
| 210302 | Түлш, халаалт | 11,522.00 | 10,349.96 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,495.20 | 1,580.81 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 16,590.30 | 16,225.11 |
| 210401 | Бичиг хэрэг | 800.00 | 1,141.65 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,410.00 | 7,542.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,226.30 | 1,311.29 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,154.00 | 360.20 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,000.00 | 5,869.97 |
| **2105** | **Нормативт зардал** | 16,000.00 | 15,426.26 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 12,500.00 | 12,486.26 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,500.00 | 2,940.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,961.10 | 7,954.80 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,707.50 | 4,701.20 |
| 210604 | Урсгал засвар | 3,253.60 | 3,253.60 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 9,911.30 | 9,848.40 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,911.30 | 9,848.40 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,429.70 | 1,350.43 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 540.00 | 432.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 340.50 | 161.18 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 450.00 | 186.69 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 105.00 | 55.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 340.00 | 198.00 |
| 210807 | Газрын төлбөр | 555.20 | 317.56 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 99.00 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 360.00 | 190.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 360.00 | 190.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 360.00 | 190.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 355,755.00 | 355,755.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 355,755.00 | 355,755.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 355,755.00 | 355,755.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 0.018 | 0.018 |
| 620001 | Удирдах ажилтан | 0.001 | 0.001 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 0.014 | 0.014 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 0.003 | 0.003 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **0.018** | **0.018** |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 0.011 | 0.011 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 0.007 | 0.007 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **99,575.21** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **99,575.21** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 75,775.21 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 18,183.12 |
| 210101 | Үндсэн цалин | 18,183.12 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 7,621.43 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 7,621.43 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,931.66 |
| 210401 | Бичиг хэрэг | 540.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,191.66 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 10,269.00 |
| 210502 | Хоол, хүнс | 10,269.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,080.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,080.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 24,710.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 24,710.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 7,980.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,980.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 23,800.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 23,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 23,800.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **380.00** |
| 222001 | Тоног төхөөрөмж | 380.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 99,575.21 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 99,575.21 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 67,592.56 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 31,982.65 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Интер аудит ХХК-ийн гэрээт аудитор Г.Алтанцэцэг, Интер Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр нар гүйцэтгэж, хяналтыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн №06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Зоонозын өвчин судлалын төв нь халдварт өвчнөөс хүн амыг урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чадавхийг бэхжүүлэх лабораторит суурилсан тандалт судалгааг эрчимжүүлэх халдвар эсэргүүцэх оновчтой зөв бодлого зохицуулалтаар хангах зорилготойгоор, нийгмийн эрүүл мэндийн чиг үүргийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт, дотоод аудитын нэгж хэлтэс байхгүй, үйл ажиллагааны заавар журам гаргаж мөрдөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зоонозын өвчин судлалын төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 322,040.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 4,830.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 3,622.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 6,220.65 | 7,941.09 | 1,720.44 |
| Бараа материал | 28,961.96 | 30,077.64 | 1,115.68 |
| Үндсэн хөрөнгө | 324,602.68 | 315,367.98 | (9,234.70) |
| **Нийт хөрөнгө** | **359,785.28** | **353,386.71** | **(6,398.58)** |
| Өр төлбөр | 6,220.65 | - | (6,220.65) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 353,564.63 | 353,386.71 | (177.92) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **359,785.28** | **353,386.71** | **(6,398.58)** |

Авлага дансны үлдэгдэл 1,720.4 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны ажиллагсадтай холбогдсон авах авлага барагдаж, татвар, нийгмийн даатгалын төлбөрт урьдчилан 3964.6 мянган төгрөгийг шилжүүлсэн, бусад байгууллагаас авах авлага өссөнтэй холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,115.68 мянган төгрөгөөр өссөн нь 12,626.3 мянган төгрөгийн үнэ төлбөргүй эм хангамжийн материал , 37,378.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 85,738.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 9,234.7 мянган төгрөгөөр буурсан нь 23,431.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй орлогодож, 6,281.0 мянган төгрөгийн эмнэлэгийн тоног төхөөрөмж худалдан авч, 38,946.8 мянган төгрөгийн элэгдлийн зардалтай гарсантай холбоотой.

Өр төлбөр дансны үлдэгдэл 6,220.65 мянган төгрөгөөр буурсан нь татвар, нийгмийн даатгалын өр төлбөрөө барагдуулж дууссантай холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 177.92 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 355,755.0 мянган төгрөг, урсгал зардлыг нийт 355,755.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 355,755.0 мянган төгрөг, урсгал үйл ажиллагаанд 352,638.1 мянган төгрөгийг зарцуулж, үлдсэн 3,116.9 мянган төгрөгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2021 онд нэмэлт санхүүжилтээр Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас корона вирусын сургалт, судалгаа хийх зориулалтаар 62,494.6 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 5,500.0 мянган төгрөгийн, дээд шатны байгууллагаас 30,020.6 мянган төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон өөрийн орлого 1,960.0 мянган төгрөгийн, нийт 99,575.21 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэн, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

### 3.8 Аудитын гол асуудал

Төсөвт төвлөрүүлэх ёстой татвар, НДШ-ийг урьдчилан шилжүүлж 4.0 сая төгрөгийн авлага үүсгэсэн.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих нийт 147 мэдээ байршуулахаас 2 мэдээг хугацаа хоцроон байршуулсанаас өөр алдаа илрээгүй.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжиийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар зөрчилгүй санал дүгнэлт өгсөн бөгөөд балансын урамшуулал илүү олгосон 2,284.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосныг хугацаанд нь барагдуулсан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарах ауудал байхгүй

## 4. Аудитын илрүүлэлт

### 4.1 Завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудит

Завсарын үеийн аудитад хамрагдаагүй байна.

### 4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит

Аудитаар нийт 8,751.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4,361.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4,390.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

### 4.2.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй.

### 4.2.2 Төлбөрийн акт

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

- ✓ *Засгийн газрын 382 дугаар тогтоолын 1-р хавсралтыг зөрчин ажилтанд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэлийг 225.7 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон*
- ✓ *Жолоочийн дансанд анхан шатны баримтгүйгээр 171.0 мянган төгрөгийн сэлбэгийн мөнгө шилжүүлсэн.*
- ✓ *Төсөвт төвлөрүүлэх ёстой татвар, НДШ-ийг урьдчилан шилжүүлж 3,964.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн*

*1.2. <u>Шийдвэрлэлт:</u>*

- ✓ *Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалын 4.2.3.3 заалтыг үндэслэн илүү олгосон нэмэгдэл хөлс, анхан шатны баримтгүй сэлбэгийн үнэ, татвар, НДШ-ийн авлага зэргийг буцаан төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.*

### 4.2.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй байна.

### 4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

- ✓ *4,390. 0 мянган  төгрөгийн зардлын и-баримтыг бүрэн бүрдүүлээгүй;*

*1.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:*

- ✓ *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ."; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хооронды бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ."; гэж заасныг хэрэгжүүлж ажиллах*
- ✓ *Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах;*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын  25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Санхүүгийн тайлангийн аудитын асуудал** | | | | | | | | | | | |
| | Зоонозын өвчин судлалын төв | 4 | 8.8 | | | 3 | 4.4 | | | 1 | 4.4 |
| **Дүн** | | **4** | **8.8** | | | **3** | **4.4** | | | **1** | **4.4** |